

## КАЗАХ ҮНДЭСТНИЙ ЭТНОГЕНЕЗИЙН ХӨГЖЛИЙН ЗАРИМ АСУУДАЛД

*М.Хурметхан\**

Төв Ази дахь Казах үндэстэн орон зай, цаг хугацаа, хөдөлгөөнд этногенез, нийгэм-түүх нь нийт хүн төрөлхтөний хөгжлийн зүй тогтлын дагуу хөгжиж иржээ. Энэхүү хөгжил нь гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөн дор өрнөсөн байна. Казах үндэстний хөгжлийн гадаад хүчин зүйлд Дэлхийн тодорхой орон зай дахь биосфер хамардаг бол дотоод хүчин зүйлд нь Казах үндэстэний өвөрмөц этногенез, түүний хөгжлийн зүй тогтол багтдаг юм.

Казах үндэстэний гарвал үүсэл, хөгжил нь хүн төрөлхтөний нийтлэг гольдролд багтах боловч, орон зай, цаг хугацаа, этногенезийн хувьд бие даан хөгжих болсноор өөрийн өвөрмөц хуулийн дагуу урагшлан хөгжсөн гэж үзэж болох талтай юм.

Аливаа ард түмний гарвал үүсэл, бүрэлдэн тогтож хөгжсөн асуудлыг судлах нь уг ард түмний хөгжлийн зүй тогтлыг танин мэдэх гол түлхүүр болдог. Этногенезийн асуудал нь маш нарийн төвөгтэй ээдрээтэй хийгээд генетик, математик, сэтгэлзүй, социологи, демограф, хэл, антрополог, археологи, түүхийн асуудлыг иж бүрнээр нь авч үзэж байж тодорхойлох зүйл юм. Угсаатан бүр өөрийн гэсэн өвөрмөц шинж тэмдэг, хөгжлийн зүй тогтолтой байдаг бөгөөд энэ нь тэдний физик хэлбэр, хэл, соёл, нийгэм, түүх, генетикийн өвөрмөц байдал, хүн амын тоо, төрөлт, үхэл, сэтгэл зүй, удамшлын өвчин хүртэлх бүхий л зүйлд илэрлээ олдог. Өөрөөр хэлбэл, этносын ерөнхий дүр төрх, өвөрмөц шинж нь тэрхүү этност нөлөөлсөн гадаад хүчин зүйлийн нөлөө, дотоод хөгжлийн гадаад илрэлийн шинж тэмдэг юм.

Казахын ард түмний гарвал үүслийг судлахдаа хүн, хүн төрөлхтөн, түрэг угсаатны гарал үүсэл, хөгжлийн үндсэн дээр казах үндэстний өөрийн өвөрмөц этногенез, антропологийн материалд үндэслэх нь чухал байдаг. Гэхдээ хэдэн арван мянган жилийг ардаа үлдээсэн ард түмний хувьд тэдний бичгийн болон археологийн материал ихээхэн хомс байгаа нь зөвхөн биологийн арга зүйд тулгуурлахаас өөр аргагүй байдалд хүргэдэг. Эртний аж төрөгсдийн палентологи антропологийн баримтын үндсэн дээр тэдний угсаатны бүрэлдэхүүн, нилээд хэмжээний түүх-соёлын үе шатан дахь генетикийн харилцан холбогдолыг тодорхойлж болох боломжийг өнөөгийн шинжлэх ухааны судалгааны үр дүн олгож байна. Антропологи нь цаг

\*М.Хурметхан-ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

хугацаа, орон зай дахь хүний биеийн физик өөрчлөлтийг судлах бөгөөд хоёр, гурав дахь нь г.м зэргийн шинж чанараар бүх хүн өөрсдийн биологийн байр байдлаас шалтгаалан өвөрмөц байдгийг тодорхойлдог. Английн эрдэмтэн Д.Холдений тэмдэглэснээр Хүн бол дэлхийн гадаргуу дахь хамгийн олон шинж бүхий хэлбэр гэсэн нь оновчтой тодорхойлолт болдог билээ. Хүмүүсийн биологийн чанарын цогц нь тэдний физик болон генетикийн тодорхойлолтоор тодорхойлогдоно. Гарвал үүсэл нь нэгтэй хүмүүс физик, антропологийн хувьд адил байх төдийгүй тэд дотоод хөгжлийн зүй тогтлын хувьд нэгдмэл байж, антропологийн хэв шинжийг бүрдүүлнэ. Хүмүүсийн удам дамждаг физик өвөрмөц шинж нь тодорхой давтамжтай тохиолдох бөгөөд тэр нь гарвал үүслийн гол шинж тэмдэг байдаг юм. Тиймээс физик шинж нь хэл, соёл, угсаатан зэрэг нийгмийн үзэгдэлтэй харьцуулахад угсаатны хэв шинж хүмүүсийн нилээд тогтвортой хийгээд биологийн нийгэмлэг болно. Хэл, соёл, угсаатан нь нэг үндэстэн, улс, бүс нутгаас хоёр дахь үндэстэн, улс, бүс нутагт хэв шинж нь өөрчлөгдөхгүйгээр шилжих магдлалтай. Харин хүмүүсийн физик дүр болон тэдний өөрсдийн өвөрмөц морфологийн шинж нь тэдгээр ард түмэн түүхийн явцад нэг нэгтэй нь шууд уусан холилдохгүй юм бол тархах нь ихээхэн ховор үзэгдэл байдаг юм. Тиймээс хүмүүсийн физик шинж нь эртний овог, аймаг, угсаатны төрөл садан байхын хийгээд тэдний нүүдэл, суудал, бүрэлдэн тогтсон үйл явцын талаар шинжлэх ухааны дүгнэлт хийхэд чухал эх сурвалж болно.

Газарзүйн төрх байдлын хувьд харилцан адилгүй нөхцөлд эртний болон өнөөгийн популяциудын биологийн түүхэндэх эдгээр маш нарийн үйл явцын үндсэн шинжүүд нь физик антропологт дараах байдлаар судлагддаг билээ. Эдгээрийг амьд байгаль /индивидум/-ын антрометри, хүмүүсийн цусны бүлэг /серологи/, шүдний бүтэц зүй /одонтологи/, алга хурууны хээ /дерматоглифик/, толгойн ясны бүтэц, малтаж олсон ясны хэлтэрхий /палео антропологи/ зэрэгт багтаан авч үздэг.

Казахстаны эртний орон нутгийн популяцийн эдгээр болон бусад антропологийн үзүүлэлтүүд хийгээд орчин үеийн казахуудын тэрхүү үзүүлэлтүүдийг угсаатны болон түүхэн үүднээс харьцуулан авч үзэх нь шинжлэх ухааны хувьд ихээхэн чухал ач холбогдолтой байдаг. Орчин үеийн шинжлэх ухаанд казах үндэстэн болон тэдний өвөг дээдсийн тухай антропологи, генетик, археологи, түүх, соёл, демограф гэх мэт арвин их материал хуримтлагдсан хийгээд өнөөгийн үеийн тухайд нэгэн адил өргөн дэлгэр судлагджээ.

Эдгээр судалгааны үр дүн нь өнөөгийн казахуудын өвөг дээдэс нь нэн эртнээс Казахстаны нутгийн уугуул оршин суугч хийгээд нэгдмэл гарвал үүсэлтэй ард түмэн болохыг баттай нотлон харуулсан байна.

Тус орны хамгийн эртний оршин суугчид нь 800 мянган жилийн өмнөх чулуун зэвсгийн үед хамаарагдах ажээ. Эртний чулуун зэвсгийн нэн их олдвор Казахстаны олон нутгаас олджээ. Тэрхүү эртний хүмүүсийн амьдрал, үйл ажиллагаа нь Казахстанд неолит болон энеолит /МЭӨ Ү-II/ үе хүртэл үргэлжилсэн ажээ. Урт удаан үргэлжилсэн энэ үед газар зүй экологийн өвөрмөц нөхцөлд хүн өөрөө зохиож эхэлсэн нь аж ахуй, соёлын өвөрмөц хэлбэр хөгжихөд нөлөөлөв. Шинэ чулуун зэвсгийн үеийн Казахстаны нутгаас олдсон түүхийн дурсгалууд тус нутгийн оршин суугчдын аж ахуй, соёлын хөгжил нь тухайн цагийн Өмнөд Ази, Хойт Энэтхэг соёл иргэншлийн түвшинд байсныг нотолдог. Гэхдээ Казахстанд оршин сууж байсан чулуун зэвсгийн үеийн хүмүүсийн физик дүр төрхийн талаар ямар нэг зүйл хэлэх боломжгүй бөгөөд энэ нь тэдний яснаас хадгалагдан үлдсэнгүйтэй холбоотой. Нөгөө талаар бусад материал, хөрш зэргэлдээ нутгаас олдсон антропологийн олдворууд Казахстаны эртний оршин суугчдын гаднах галбир төрх нь өвөг европжуу төрхийн /протоевропеид/ байсан хийгээд тэдэнтэй төстэй хүмүүс Зүүн, Баруун Европ, Өмнөд Азид суурьшсан байжээ. Эрдэмтэдийн нотолж байгаагаар Казахстанд чулуун зэвсгийн үед ч, түүнээс хойш оршин суугчдын антропологийн үндэс нь өвөг европжуу байсан болов уу хэмээн үздэг ажээ.

Казахстанд хүрэл зэвсгийн үеэс /МЭӨ ХҮII-IX/ орон нутгийн угсаатны бие даасан соёл байсан нь тодорхой болов. Археологи, палеонтологи-антропологийн баримтаар энэ үеийн Казахстаны уугуул оршин суугчид нь Евроазийн их этно-соёлын бүс нутгийн голд бөөгнөрөн суурьшсан, тэдний хүн амын тоо ихтэй, өвөг европжуу төрхтөн их хээр талын төлөөлөгчдийн нэгэн хэв шинж байсныг нотолжээ.

Казахстанд оршин суудаг овог аймгууд тэр нутагтаа ч нэгдмэл антропологи, угсаатан-газар нутаг болон аж ахуй-соёлын хувьд нэгдмэл байсан нь нотлогджээ. Үүний тод жишээ нь казахын нутгаас олдсон андроновын /олдсон газрын нэр/ соёл хэмээн нэрлэгдэх археологийн дурсгал бөгөөд энэ нь металл боловсруулах технологийг адил тэгш эзэмшсэн байсныг нотолжээ. Ийнхүү орон нутгийн эртний аймгуудын соёл-түүхийн нэгдэл нь хэдэн мянган жилийн туршид угсаатан бүрэлдэн тогтох суурь болж, Казахстан дахь эртний популяцийн маш чухал алтан багана болсон хийгээд хожим нь Казахстанд уугуул угсаатан бүрэлдэн хөгжих гол эх үүсвэр болжээ.

Казахстаны янз бүрийн газраас археологийн малталтын үед олдсон хэд хэдэн толгойн яс нь эндэхийн эртний овог аймаг нь европжуу төрхтөн байсныг харуулжээ. Гэхдээ дотор нь хамгийн багаар бодоход орон нутгийн хоёр галбир төрхийн хэлбэр байжээ. Энэ нь нэгдүгээрт, эртний европеидын салбар болох хээр талын /андронов/

антропологийн галбир, хоёр дахь нь Газрын дундад тэнгисийн хэмээх галбир ажээ. Эдгээрээс ажиглахад Казахстаны угсаатны түүх нь угсаа-генетикийн бүрэлдэн тогтох явц нь урт удаан хугацааны туршид дээрх хоёр хэлбэр хийгээд зарим нэгэн бусад европжуу хэлбэрийн оролцоотойгоор бүрдсэн хэмээн эрдэмтэд үздэг ажээ.

Казахстаны хүрэл зэвсгийн үе бүхэл нэгэн түүхэн үе хэмээн үздэг. Орон нутгийн европжуу угсааны хэлбэрүүдийн соёл-аж ахуйн уламжлал нь бүс нутгийн соёл-аж ахуйн угсаатны үндэс байхын хамтаар тэдний хувьд иран хэлний хойт аялгуу хөгжиж байжээ. Энэхүү хүрэл зэвсгийн үед бүрэлдэн тогтсон бүхий л соёл-түүх нь казахын өвөг дээдсийн анхны гал голомт юм. Орчин үеийн Казахстаны нутаг нь тэрхүү өвөг дээдсээс үржсэн дараагийн олон олон удам угсааны жинхэнэ эх орон нь болсон байна. Түүний дараагаар Казахстанд хүрэл зэвсгийн оронд эртний төмөр зэвсгийн үе /МЭӨ VII-V зуун/ эхэлжээ. Металл боловсруулах, мал аж ахуй, газар тариалангийн хөгжил шинэ шатанд гарахын хамтаар энэ нь угсаатан-түүхийн нийтлэг бий болж хөгжихөд ихээхэн нөлөө үзүүлэв. Нүүдэлчид байгалийн шалгаралын замаар ялгаран, тэдний дундаас аймгийн удирдагчид тодрон, “нийтийн” засаглалын институт хүчтэй болж, овог аймгуудын харилцаа, худалдаа хөгжжээ. Аймгуудын шинэ нэгдлүүд болох аймгуудын холбоо бий болсон бөгөөд тэдний дунд саг-скиф аймаг гол байрыг эзэлж байжээ.

Казахстанаас олдсон эртний төмөрийн үеийн хүний толгойн ясыг нарийвчлан шинжлэх явцад ямар нэгэн өөрчлөлт ажиглагдсан бөгөөд тэр нь дорно зүгээс ирсэн популяцийн нөлөө байгаа нь харагджээ. Сагийн үеийн Казахстан дахь эртний популяцийн дүр төрхөд монголжуу төрхийн шинж илрэн, тэр нь нийт физик шинж чанарын 1/5-ийг эзлэж байжээ. Манай эрин хүртэлх мянган жилийн дунд үед Казахстанд дорно зүгээс хүмүүс ихээр ирж суурьшсанаар чухамдаа Казахстаны нутаг дэвсгэрт монголжуу төрхтөн угсааны салбар элементүүд бий болж, дундад зууны сүүл ойртох тусам аажмаар хүчтэй өргөжсөн байна. Тэгээд дараа нь эртний эринд Казахстаны нутаг дэвсгэрт скиф-саг болон скиф-сарматын гэсэн соёлын хоёр гал голомт байсан нь тогтоогджээ. Энэхүү хоёр соёлын төлөөлөгчид нь бие биендээ ойр төстэй байсныг археологийн материалууд нотлон үзүүлжээ.

Манай эриний 1 мянган жилийн хоёр дахь хагаст Казахстаны нутгийн оршин суугчдын дунд /түргийн үеийн эхэн/ патриархал харилцаа үндсээр өөрчлөгдөж, нийгэм-эдийн засгийн томоохон өөрчлөлтүүд эхэлсэн байна. Мал аж ахуйн хамтаар газар тариалан хөгжиж, суурин соёл иргэншлийн үндэс тавигдав. Тус нутагт VI зууны дунд үед Түрэгийн хаант улс байгуулагдав. Казахстаны зүүн өмнөд хэсэгт Түрэг, түүний дараа Карлукын хаант улс байгуулагджээ. VII-IX зуунд Казахстаны зүүн-хойт

хэсэгт Кипчакийн холбоо бий болов. X-XI зуунд Долоон Улсын /Жетису/ нилээд хэсэг нь Караханидын бүрэлдэхүүнд оржээ. X-XI зуунд Казахстаны төв хэсэг нь Дешти-Кыпчак хэмээх нэрээр алдаршсан байна.

Энэ үед Казахстаны уугуул оршин суугчид байнга нүүдэллэн аж төрж байсан учир угсааны бүрэлдэхүүн нь холилдох үйл явц урьд өмнөхөөс илүү их хэмжээтэй явагдах болов. Энэ үед Казахстаны уугуул хоёр угсаа болох европжуу, монголжуу төрхтөний харьцаа 1/3-тай тэнцүү байжээ. Ихэнх уугуул популяцийн хувьд нэгдэх мянган жилийн эцэс, хоёр дахь мянган жилийн эх нь нийгэм –эдийн засаг болон соёлын хөгжлийн чухал үе байлаа. Казахстаны нилээд суурин болон хагас суурин газрууд, хотын тоо, хэмжээ өсч, хол ойрын аймгийн төрөл аймгийн нэгдлийн эв нэгдэл, нэгдэх үйл явц эрчимтэй өрнөв. Энэ үеийн хүн ам нь тодорхой нийтлэг угсаатны үндэс бүрдүүлэх чиглэлд орсон байна.

XIII зуунд казах угсаатны бүрэлдэн хөгжих явц урагшлан хөгжсөний гол илрэл Казахстаны нутаг дэвсгэрийн нэгдсэн төр улс дахин сэргэж, ханлигууд байгуулагдсан явдлууд юм. Ногайн орд, Өзбек болон Казахын хаант улс улс-төр-нийгмийн талаар хүчирхэгжсэн нь ихээхэн түүхэн чухал үйл явдал болсон байлаа. ХҮI зууны эхэнд тус нутгийн нүүдэлчин түрэг угсааны хүн амын нэг хэсэг нь Шайбани хааны удирдлагаар Мауреаннахрд шилжсэний дараа буурин дээр үлдсэн хүн амыг бүхэлдээ нь “Казах” хэмээн нэрлэх болов. Гэхдээ “казах” гэдэг угсаатны нэр нь түүнийг бүрдүүлсэн үндсэн хүн ам бүрэлдэн тогтсон цаг үеэс нилээд хожим хэрэглэгдэх болсон нь тодорхой болов.

Антропологийн үүднээс үзэхэд дорно зүгээс овог аймгууд шилжин ирснээр Казахстаны орон нутгийн хүн амын дунд дорно угсааны салбарын эзлэх хувийн жин өсөв. Гэхдээ орон нутгийн хүн амд монголжуу төрхтөний хувийн жин түрэгийн үеэс илүү гараагүй байна. Үүний дараа казах угсаатны нийтлэг бүрэлдэхэд Долоон Улсад ХҮ-ХҮI зууны зааг дээр байгуулагдсан Казахын хаант улс их нөлөө үзүүлсэн билээ. Энэхүү угсаатан –улс төрийн нэгдэл нь орон нутгийн үйсин, канли, дулат, жалаир г.м. аймгаас бүрэлдсэн байна.

ХҮI зууны эхэнд Казахын ханлигууд нь хүн ам сийрэг суурьшсныг үл харгалзан нэгдмэл нэгэн угсаатан байжээ. Түрэг аймгууд болох үйсин, кыпчак, найман, керей, аргун, дулат, алшын болон бусад аймгуудын хэлний үндсэн дээр аман аялгууны өчүүхэн зэрэг ялгаатайгаар нэгдмэл казах хэл бүрэлдэн тогтлоо. Ерөнхийдөө Казахын ард түмэн бүрэлдэхэд угсаатны болон түүхэн орчин үндсэндээ орон нутгийн түрэг хэлтэн аймгууд болон Алтай, Өмнөд Сибирь болон Төв Азиас гаралтай түрэг болон монгол аймгуудын шилжин ирсэн төлөөлөгчид оролцсон юм.

Казахуудын угсаатны нийтлэг казах үндэстэн болж бүрэлдэх явц нь ХҮ-ХҮI зуунд Казахын хаант улс байгуулагдсантай холбогдон оргилдоо хүрчээ. Тэд нэгдмэл нэгэн угсаатны хувьд нэгдмэл газар нутагтай, материаллаг ба оюуны соёл мэдлэг, мэдээлэл нь ижил, нийт угсаатанд ойлгомжтой казах хэлээр ярилцах болсон байна.

Казахстаны дундал зуун дахь хүн амыг антропологийн үүднээс судлахад, ХҮ-ХҮII зууны туршид орон нутгийн популяцийн антропологийн бүтэц нийлээд тогтвортой болох нь анзаарагддаг ажээ.

Казахуудын антропологийн онцлог Казахстаны нутаг дэвсгэрээс олдсон антропологийн материалууд болон өнөөгийн казахуудад байдаг физик дүр төрх нь европжуу, монголжуу төрхтөний ээдрээ төвөгтэй харилцан хамаарлын үндсэн дээр, хамгийн багаар бодоход ХҮ-ХҮ зуунд бүрмөсөн бүрэлдэн тогтсон гэсэн дүгнэлт хийх үндэс болдог.

Казахуудын антропологийн нийтлэг бүрэлдэн тогтоход биологи болон нийгмийн хүчин зүйл чухал үүрэг гүйцэтгэжээ. Гарваль угсааны нийтлэг нь генетикийн хүчин зүйл болон гарал үүсэл нэгтэй байгаагаар тодорхойлогдоно. Хоёр дахь нь хөгжлийн түүхэн хүчин зүйлүүд хийгээд соёл-аж ахуй, ахуй амьдрал-зан заншлын нэгдмэл байдлаар тодорхойлогдоно. Сүүлчийн зүй тогтол нь нилээд тогтвортой байдаг биологийн онцлогуудыг харьцуулахад хувирамтгай байдаг бөгөөд, тэрчилэн антропологийн нийтлэг байдал нөлөөлж, заримдаа түүнийг хурдасгах буюу удаашруулах магадлалтай байдаг билээ. Тийм нөлөө нь ихэнх тохиолдолд шууд бус, гадаад болон дотоод хүчин зүйл, демографийн янз бүрийн түвшинд нөлөөлснөөр хэрэгжиж байжээ. Казахын ард түмний угсаа түүхийн хөгжилд нөлөлсөн өөр нэг чухал хүчин зүйл бол бүс нутгийн бодит байдлаас урган гарсан казахын Их, Дунд, Бага орд бүрэлдэн тогтож, хөгжсөн хэмээн үзэх ёстой билээ.

Ийнхүү, Казахстаны нутагт түүхийн янз бүрийн үед аж төрсөн оршин суугчид, ард түмнүүд болон казахын өөрийн угсаатан-түүх, палентологи болон антропологийн физик дүр төрх товчхондоо ийм ажгуу.

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Казах, О. Смаглов. Гарваль үүсэл. Алматы., 1994. х. 6-31.
2. Казахстан тарихы. /Казахстаны түүх/. Боть 1., Алматы., 1996. 540. х.
3. Казахстан тарихы. /Казахстаны түүх/. Боть 2., Алматы., 1998. 637.х.